

БАТЛАВ  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА *С.Дорж* Ч.ЭРДЭНЭ-ОЧИР

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ДЭД ВИГЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ  
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

202402030054-A

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 0.0/

Талын шанд

Энэхүү гэрээг нэг талаас төлөөлж Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг дарга Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг дарга Ч.Эрдэнэ-Очир (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас ашигт малтмалын 905A дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Н.Гансүх (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч/Төсөл хэрэгжүүлэгч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2024 оны 03 дугаар сарын 27 -ны өдөр байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү гэрээгээр Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг дэвсгэрт уул уурхайн тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах асуудлаар Төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн захирагааны байгууллага хамтран ажиллах талаар талуудын эрх, үүргийг тогтооно.
- 1.2. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хучин төгөлдөр болж, 2026 оны 03 сарын 27-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатай байгуулав.
- 1.3. Талуудын хамтран ажиллах төсөл, арга хэмжээний жагсаалтыг энэхүү гэрээний хавсралтад оруулсан ба (цаашид "Гэрээний хавсралт" гэх) хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

**Хоёр: ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
  - 2.1.1. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах;
  - 2.1.2. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа, үүний дотор нүүрсний экспорт, нүүрс тээвэрлэлт, хатуу хүчилттай автозам барих, гаалийн хяналтын бүс болон бусад дэмжих дэд төслүүдэд шаардлагатай газар ашиглах зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөл, боломжоор Төсөл хэрэгжүүлэгчийг хангах;
  - 2.1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны талаар сумын иргэд, төр,

- захиргааны байгууллагуудад үнэн зөв мэдээллийг өгч, төслийн үр өгөөжийн талаар таниулах арга хэмжээ, иргэдийн нийтийн болон багийн хурлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 2.1.4. Уурхайн үйл ажиллагаа болон нүурс тээврийн ажлыг эрчимжүүлж экспортыг нэмэгдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;
  - 2.1.5. Төсөл хэрэгжүүлэгчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн, түргэн шуурхай шийдвэрлэж, зохих хариуг өгөх, Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуух гомдол, саналыг хүлээн авч, харьяаллын дагуу шийдвэрлэх, төслийн хэрэгжилтийн явцад нутгийн захиргааны байгууллагаас шаардлагатай шийдвэр, компанийн үйл ажиллагааны талаарх тодорхойлолт, албан бичиг гаргах зэргээр хамтран ажиллах.
  - 2.1.6. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;
  - 2.1.7. Хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

## **ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **3.1. Ерөнхий:**

- 3.1.1. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажиллах хүчийг орон нутгийн иргэдээс түлхүү бүрдүүлэхийг эрмэлзэх, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;
- 3.1.2. Орон нутгийн оюутан залуусыг дадлага хийх нехцөл боломжоор хангаж, Хөдөлмөрийн тухай хуульд заасан гэрээ байгуулж, ажиллуулах,
- 3.1.3. Говь-Алтай аймгийн болон Чандмань сумын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, боломжтой дэмжлэг, туслалцааг үзүүлэх, байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр гэрээний хавсралтад дурдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.1.4. Эмнэлэг, сургууль, нутгийн удирдлагын байр зэрэг төрийн төсвийн байгууламжуудын халаалт болон Чандмань сумын иргэдэд ахуйн дулааны хэрэгцээнд тодорхой хэмжээний нүүрсийг үнэгүй олгох;
- 3.1.5. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хамтын ажиллагааны хүрээнд нутгийн захиргааны байгууллагад дэмжлэг болох мөнгөн хөрөнгийг зөвхөн нөгөө талын нэр дээрх албан ёсны дансанд шилжүүлнэ.
- 3.1.7. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;
- 3.1.8. Хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

### **3.2. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

- 3.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Татварын тухай

- хууль, Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 3.2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийг орон нутгийн Татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлж, холбогдох хуулийн дагуу орон нутгийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, татварыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх;

### **3.3. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

- 3.3.1. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайланг олон нийтэд танилцуулах, нутгийн иргэдийг мэдээллээр хангах ажлыг тухай бүр нь аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газартай хамтран зохион байгуулж ажиллах;
- 3.3.2. Байгаль орчны-нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу хөрс, ургамал, булаг, шанд гол, ан амьтан хамгаалах, худаг уст цэг гаргах ажлыг зохион байгуулж холбогдох нөхөн сэргээлтийг хийх.
- 3.3.3. Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, тайландаа хяналт тавьж ажиллах;
- 3.3.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг тухайн үед мөрдөгдөж байгаа хууль, эрх бүхий байгууллагаас баталсан, тогтоосон тарифын хэмжээгээр орон нутгийн төсөвт төлөх;

### **ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО**

- 4.1. Хороо нь гэрээний хэрэгжилтийн талаарх тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг батлуулахаас өмнө аймаг, сумын Засаг даргад тухайн жилийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТ, ТАЙЛАГНАЛТ**

- 5.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Засаг даргад хүргүүлнэ
- 5.2 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.
- 5.3 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.
- 6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.
- 6.3. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл (газар хедлэлт, үер, гол түймэр, хүчтэй салхи, шуурга, халдварт өвчин, байгалийн бусад аюулт үзэгдэл, хатуу хөл хорио, төрийн оролцоо)-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдсэнээр хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно. Дээрх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдалбий болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тус нөхцөл байдал арилах хүртэлх хугацаагаар харилцан тохиролцож хойшлуулж, сунгана.
- 6.4. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

## ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдоо шүүхэд гаргаж болно.

## НАЙМ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 8.1 Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.
- 8.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
- 8.4 Гэрээг Монгол хэл дээр З хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг Англи хэл дээр үйлдэж болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЧАНДМАНЬ СУМЫГ ТӨЛӨӨЛЖ  
СҮМҮН ЗАСАГ ДАРТ

Ч.ЭРДЭНЭ-ОЧИР /  
ХАЯГ: Говь-Алтай аймаг, Чандмань сум

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

СЭКЕР РЕСӨРСҮС МОНГОЛИА ХХК-ийн  
Үйл ажиллагаа хариуцсан захирал

... / Н.ГАНСҮХ /  
Хан-Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-  
р хороо, Мөхтэма Гандигийн гудамж,  
Форум төв, 5 давхар

ЧАНДМАНЬ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,  
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БУТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,  
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ,  
ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭР ХИЙХ  
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

2024 оны 03 сарын 27 өдөр

Улаанбаатар хот

Гэрээний дугаар...

**Гэрээ байгуулсан талууд:** Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг дарга Ч.Эрдэнэ-Очир /цаашид “Засаг дарга” гэх/, нөгөө талаас ашигт малтмалын 905А дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч “СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-тай хамтран ажиллах гэрээг дараах нөхцөлийг харилцан тохиролцов.

Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглахтай холбогдсон дэд бутцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллахтай холбогдон төсөл арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд

№	Хөрөнгө оруулалт хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Дүн /сая. төгрөг/
1	Сумын түүхт 100 жилийн ойн хандив	Баяр наадмын талбайн тохижилт хийх	50
2	Тэр бум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 108 сая мод тарих хөтөлбөрийн хүрээнд модны суулгац,	Амьдрах чадвар өндөртэй 1000ш модны суулгац нийлүүлэх 2024 оны 5 сарын 1нээс өмнө	2
		Мандлын цэцгийн үрсэлгээ 2000ш -ийг нийлүүлэх	2,5
3	Үерийн далан байгуулах	2024 оны 4 сард	8-10
4	Чандмань сумын өрхүүдэд нүүрс олгох	2024 онд 205 ахмад настан, амжиргааны баталгаажих түвшин доогуур 112 өрх, өрх толгойлон 59 өрх тус тус 0.5 тн нүүрс	